



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 08 өдөр

Дугаар А/26

Бөхт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Л.Мөнхбадрах	(Засаг даргын орлогч)
Гишүүд	Х.Уугандорж	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	У.Баянмөнх	(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Б.Нарандэлгэр	(Газрын даамал)
	Э.Сумьяа	(Цог багийн Засаг дарга)
	Д.Шинэбаяр	(Талын нар багийн Засаг дарга)
	М.Цэвэгдорж	(Бөхт багийн Засаг дарга)
	Б.Баянжаргал	(Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга	Х.Хундмаа	(Санхүүгийн албаны дарга)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын саналыг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, хэтийн төлөвтэй уялдуулан нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх ажлыг холбогдох журмын дагуу үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (Л.Мөнхбадрах)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулах 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/20 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

4823010059